

Дунбүрээгийн Батсүх<sup>1✉</sup>

<sup>1</sup>Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,  
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,  
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

## Монгол Алтайн пазырык булшны ваар сав: Ангилал, нэр томъёо ба хээ чимэглэл

**Товчлол.** Монгол Алтайд малтан судласан пазырыкийн 21 оршуулгын цолцолборын 50 булшнаас илэрсэн 68 ваарны 34 ваарыг их бага хэмжээгээр сэргээн харах боломжтой гэж үзэн нэгтгэн дүгнэж ангилах оролдлогыг хийв. Монголын пазырыкийн ваар савны ангилал, нэр томъёо, хээ чимэглэлийн асуудал нь ерөнхийдөө ангиллын эргэн тойронд төвлөрсөн бөгөөд ваар савны үйлдэх технологи, он цагийн асуудлыг хөндөлгүй зөвхөн хэрэглээний асуудлыг товч авч үзлээ. Хээ чимэглэлийг 3 хэлбэрийн 9 төрөлд хуваан ангилав.

**Түлхүүр үг.** Төмрийн түрүү үе, Пазырыкийн соёл, пазырыкийн булш, ваар сав, домбо, хотго, бутан, зурмал хээ

Batsukh Dunburee<sup>1✉</sup>

<sup>1</sup>Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences Building-1,  
Peace avenue. Ulaanbaatar-13330, Mongolia

## Ceramics in Pazyryk tombs of the Mongolian Altai: Classification, Terminology and Patterns

**Abstract.** Presently, within the Mongolian Altai Mountains, specifically within the Bayan-Olgii province, a total of 68 pottery artifacts have been unearthed from 50 graves across 21 burial complexes. Consequently, this article aims to delineate the classification and terminology pertaining to Mongolian Pazyryk culture pottery types based on the aforementioned 68 objects, alongside an examination of patterns.

Pazyryk study literature has identified over ten distinct types of pottery, categorized according to discernible features or attributes. Among these, the most prevalent include jugs, vases, crocks, pots, and bowls. However, within the Pazyryk tombs in Mongolia, only three types of pottery—jugs, vases, and crocks—were discovered, leading to their classification into 3 primary types and 5 subtypes.

The structural composition of Pazyryk pottery diverges from that of Xiongnu pottery, typically exhibiting a coarser and more rugged texture. Nonetheless, Pazyryk pottery showcases a greater richness and variety of patterns compared to its Xiongnu counterpart.

Mongolian Pazyryk pottery designs or patterns are categorized into 3 main forms encompassing 9 types. An examination of Mongolian Pazyryk pottery, as well as the broader Pazyryk culture, suggests a well-developed and refined pottery artistry characterized by diverse and distinctive forms, intricate patterns, decorations, and a distinction between funerary and domestic pottery. It appears that these vessels were crafted and distributed locally by indigenous artisans, albeit with discernible influences from neighboring cultures and even distant regions.

**Key words.** Early iron age, Pazyryk culture, pazyryk tomb, pottery, jug, crock, vase, patterns, painted patterns

### Удиртгал

Пазырыкчууд нас барагсдынхаа булшинд оршуулгын эздийг хойд насандаа хэрэглэхэд нь зориулан дагалдуулдаг тахилгын үндсэн хэсгийн нэг хэрэглэгдэхүүн нь ваар сав билээ. Энэхүү олдвор нь булш оршуулга ба хот суурины малтлагын аль алианаас нь олон тоотой илэрдэг ба тухайн соёлын он цаг ба угсаатны онцлогийг илэрхийлж чадахуйц мэдээллийг өгдөг бөгөөд

ерөнхийдөө археологийн судалгаанд онцгой байр суурьтай байдгаас гадна пазырыкийн соёлын судалгаанд ч чухал эх хэрэглэгдэхүүн билээ. Иймээс ч Оросын судлаачид пазырыкийн соёлын ваар савны хэлбэр төрх, оршуулгын зан үйл дэх байр суурь, нийгмийн агуулга, соёлын дурсгалт зүйл болохыг олон талаас нь дэлгэрэнгүй судалсан төдийгүй технологийн шинжилгээнүүд ч багагүй хийгджээ. Харин Монголын пазырыкийн

соёлын дурсгалыг 2005 оноос хойш судалж байгаа боловч одоогоор ваар савны тусгайлсан судалгаа хийгдээгүй байна. Иймээс, юуны өмнө манай улсад малтан судалсан 50 булшны 68 хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монголын пазырыкийн соёлын ваар савны археологийн судалгаа буюу төрөл зүйлийн ангилал ба нэр томъёо, мөн хээ чимэглэлийн судалгааны асуудлыг энэхүү өгүүлэлд тодорхойлон гаргахыг зорив.

Ерөнхийдөө пазырыкийн оршуулгын соёлд хамгийн түгээмэл илэрдэг олдворын нэг бол ваар сав юм. Ваар савыг булшинд оршуулсан хүн бүрийн тоогоор нь тавьдаг гэж үздэг [Кубарев, 1991: 59; Кирюшин, Степанова, 2004: 24]. Зөвхөн хамгийн эртний зарим пазырык булшинд л түрүү скифийн үеийн булшны уламжлалыг даган вааран сав дагуулаагүй тохиолдол байдаг. Гэхдээ тухайн нас барагчийн нийгмийн зэрэг дэвээс шалтгаалан байр суурь өндөр болох тусмаа дан шавар ваарнаас гадна мод, үндэс ба үйсэн, мөн амьтны эвэр, арьсан сав суулга ч тавьдаг байсан. Түүнчлэн нэг хүнд зориулж нэгээс олон тооны шавар сав ч тавих тохиолдол цөөн боловч бий [Кубарев, Шульга, 2007: 59]. Органик эдлэлийн хадгалалтын байдлаас шалтгаалан олонх булшинд зөвхөн шавар сав суулга нь хадгалагдан үлдсэн бололтой байдаг. Зарим тохиолдолд эвэр суулгыг дууриалган хийсэн шавар ваар сав гардаг нь үүнийг нотолж байгаа жишээ юм.

“Сонгодог” пазырык булшинд буюу “дүнзэн бунхантай” булшинд ваар савыг хүнийхээ хойд талд, нүүрэн тушаа нь байх оршуулгын идээний хэсэгт модон гэвш ба төмөр хутганы хамтаар тавьсан байдаг. Эдгээр шавар савнууд жинхэнэ бодит хэрэглээний зүйлс үү эсвэл оршуулгад зориулсан зүйлс үү гэдэг талаар маргаан бий. Пазырыкийн соёлын сууринуудаас вааран тогоо, хотго, аяга хэлбэрийн шавар савнууд илэрдэг төдийгүй булшны дараас чулуун дундаас зөвхөн эдгээр төрлийн савнуудын хагархай гардаг ажээ. Харин булшнаас гардаг ихэнх домбо ба бутан хэлбэрийн шавар савнууд сууринуудаас огт илэрдэггүй тул зөвхөн оршуулгад зориулж тусгайлан хийдэг “зан үйлийн” эдлэлүүд байсан бололтой [Кубарев, Шульга, 2007: 59]. Оршуулгын дурсгал ба сууринаас илэрдэг шавар савны хэлбэрүүд, түүний тооны ба чанарын үзүүлэлтүүд эрс зөрөөтэй байдаг зүй тогтол зөвхөн Алтайн бүс нутгийн хүрэл ба түрүү төмрийн үед ажиглагддаг төдийгүй Монголын Хүннүгийн жишээн дээрээс ч харагддаг.

Пазырыкчууд шавар саваа хүннүчүүд шиг эргэх хүрдэн дээр бус харин туузан аргаар гараар барьдаг байсан учир тэгш бус хэмтэй хийх нь түгээмэл байжээ. Мөн гараар барьдаг байсан нь

ваарны төрөл ба хэлбэр маш олон янз болох нэг шалтгаан болсон юм. Пазырыкийн ваарыг задгай жигд бус гал дээр шатаасан байдаг тул голлон улаавтар өнгөтэй байх боловч хар, саарал өнгийн толботой байдаг юм. Үүнээс гадна хар, саарал, шаргал өнгийн ваарууд бий [Кубарев, 1991: 54].

### **Пазырыкийн ваар савыг судалсан тойм**

Пазырыкийн оршуулгын цогцолборуудын судалгааг 1940-өөд оны сүүлчээс идэвхтэй нийтэлж эхэлсэн байдаг юм. Эхэндээ гол төлөв том хэмжээтэй элит буюу язгууртны цогцолборуудын хэрэглэгдэхүүнийг нийтэлж байснаа 1980-аад оноос “жирийн иргэдийн” гэж ангилж болох дунд, жижиг хэмжээтэй оршуулгын дурсгалуудыг, харин сүүлийн арваад жилд суурины хэрэглэгдэхүүнийг ч нийтэлж байна. Одоогоор 20 орчим нэгэн сэдэвт зохиолын хүрээнд дээрх хэрэглэгдэхүүн нийтлэгдээд байгаа бөгөөд энэ бүгдэд ваар савны материалыг их бага хэмжээгээр боловсруулан хэвлэсээр иржээ.

М.П.Грязнов, С.В.Киселев, С.И.Руденко, В.Д.Кубарев, А.С.Суразаков, В.И.Молодин, Н.В.Полосьмак, Ю.Ф.Кирюшин, А.А.Тишкин нарын дээр дурдсан бүтээлүүдэд илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний тодорхойлолт ба ангилал, харьцуулалт, тусгай асуудлуудыг нь хөндсөн байдаг. Харин пазырыкийн ваар савны технологийн дүн шинжилгээ бусад нарийн судлагдсан үеүдийн ваар савтай харьцуулахад ховор боловч хийгдсэн байна [Молодин, Ламина 2000; Кирюшин и др. 2003: 90]. Будмал хээтэй ваар савны тухай тусгай судалгаанууд цөөнгүй гарсан нь [Кубарев, 1990; Кирюшин, Степанова 2000 г.м.] уг сэдэв пазырыкийн соёлын гадаад хэлхээ холбооны тухай асуудалтай холбогддог сонирхолтой өнцгийг илэрхийлж байна.

Нэрт судлаач В.Д.Кубарев Уулын Алтайн өмнөд хэсэгт орших Уландрык, Юстыд, Сайлюгем зэрэг газруудад буй пазырыкийн дурсгалт газруудыг малтан судалж цуврал нэгэн сэдэвт зохиолуудыг хэвлэн нийтлүүлсэн билээ [Кубарев, 1987, 1991, 1992]. Уг ажлаа үргэлжлүүлж 2007 онд П.И.Шульгагийн хамт Чуй ба Урсула голын хөндийн пазырыкийн оршуулгын дурсгалуудын судалгааг хэвлэжээ [Кубарев, Шульга 2007]. Дээрх дөрвөн бүтээлд тус бүрд нь ваар савыг тусгайлан авч үзсэн бүлэг зүйл байгаа бөгөөд нэгдмэл арга зүй, нэр томъёогоор маш цэгцтэй бичсэн байдаг тул бүхэлд нь нэгэн цогц судалгаа гэж хэлж болно. Тэрээр ваар савыг хотго (горшок) ба домбо (кувшин) гэсэн хоёр үндсэн төрөлд хуваан үздэг. Үүнийгээ дотор нь олон жижиг дэд төрөлд хуваан задалдаг [Кубарев, 1991: 55-58]. Тэрээр пазырыкийн ваар савны гарал үүсэл, тэдгээрийн

хэрэглээний асуудал зэрэг судалгааны олон сэдвийг хөндөн авч үзсэн байдаг нь одоо ч сонирхолтой хэвээр байна. Ерөнхийдөө В.Д.Кубарев урьд өмнө жижиг хэмжээний цуглуулгууд буюу ямар нэгэн оршуулгын цогцолборын хэмжээнд хийгдэж байсан судалгааг өргөн хүрээтэй болгож судалгааны үндсэн бүх сэдвүүдийг хөндөн, олон асуудлаар өөрийн тайлал, гаргалгааг хийсэн юм.

Пазырыкийн шавар савны ангилал зүйн асуудалд анх удаа тусгайлан анхаарал хандуулан үзсэн нь А.С.Суразаков юм. Тэрээр оршуулгын дурсгалуудаас илэрдэг шавар савнуудыг: горшок, кувшин, миска, плошка, кружок, корчаг, сосуды баночного типа гэж ангилсан байдаг [Суразаков, 1989]. Ерөнхийдөө тухайн үед скифийн төрлийн археологийн соёлуудаас илэрдэг шавар савуудыг ангилж нэрлэхдээ дээрх болон төстэй нэр томъёог ашиглаж байсан боловч хооронд нь хольж хутгах, нэг ваарыг өөр өөрөөр нэрлэх явдал элбэг байсан тул маш нарийн бөгөөд оновчтой тодорхойлж, түүнийгээ тууштай баримтлах шаардлага бий болжээ. Ийм нөхцөлд Н.Ф.Степанова пазырыкийн шавар савны ангилал ба нэр томъёоны асуудлаар тусгайлан судалж өгүүлэл гаргасан нь [Степанова, 1998] одоо нэгэнт олонх судлаачдын голлон баримталдаг баримжаа болсон байна. Энэ чиглэлийн судалгаагаа тэрээр гүнзгийрүүлж 2004 онд Ю.Ф.Кирюшиний хамтаар нийтлүүлсэн Катунь голын дунд урсгалын дагуух түрүү төмрийн үеийн оршуулгын дурсгалуудын талаарх нэгэн сэдэвт бүтээлдээ пазырыкийн соёлд хамаарах 313 шавар савны хэрэглэгдэхүүнийг нэгтгэн авч үзээд нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн нь уг сэдвийн судалгаанд томоохон алхам болсон байна [Кирюшин, Степанова, 2004: 24-44]. Тэрээр пазырыкийн ваарны хэлбэр зүйн судалгааны үндсэн бүх асуудлууд болох: ангилал, нэр томъёо, хээ чимэглэл, өнгө, зэргээс гадна булшны дарааснаас гарсан вааруудад анхаарал хандуулах шаардлагатайг анх удаа судалгааны хүрээнд дурдаж үндсэн тодорхойлолтыг хийжээ.

В.С.Миронов 2000 онд хамгаалсан докторын диссертацидаа Катунь голын дунд урсгалын пазырыкийн булшнаас гарсан 97 ваар савны хэрэглэгдэхүүнд тулгуурлан ангилал хийсэн байна [Миронов, 2000]. Гэхдээ тэрээр өмнөх үеийн судлаачдаас ялгаатай нь зөвхөн хэлбэр төдийгүй мөн хээ чимэглэл ба үүргийг нь харгалзан үзсэн ажээ. Тэрээр ваар савын домбо (кувшин), хотго (горшок), бутан (кринка) гэсэн 3 үндсэн төрөлд хуваасны дээр хээ чимэглэлийн хувьд хар өнгөөр будсан, товгор наамал хээтэй ба шинэхэн ваарны бэлдмэл дээр зурсан хээтэй гэж ангилсан байна.

Пазырыкийн ваар савны гарал үүслийн талаар сонирхолтой саналуудыг Л.С.Марсадалов

гаргасан нь домбо, бутан харь гаралтай, магадгүй баруун зүгээс, түүний дотор Кавказ, Анатоли, Дундад Азиас ирсэн бололтой, харин хотго бол өмнөх майэмир-бийкений соёлын үеэс уламжлагдсан орон нутгийн гаралтай гэсэн санал юм [Марсадалов, 2004: 40]. Мөн эзлэхүүний хэмжилт хийсний үндсэн дээр пазырык ваар савны хэмжээ түүний эзний нийгмийн зэрэг дэвтэй шууд хамааралтай байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

2023 онд Алтайн их сургуулийн докторант Му Цзиньшань пазырыкийн ваар савыг тусгайлан судалсан диссертаци хамгаалсан нь одоогоор энэ сэдвээр хийгдсэн хамгийн том хэмжээний бүтээл болжээ [Му, 2023]. Тэрээр энэхүү бүтээлдээ гол төлөв Орос Алтайн 600 гаруй ваар савны хэрэглэгдэхүүнд тулгуурласны дээр Монгол ба Хятадын Алтайн цөөн боловч ваар савны материалыг ашигласан байна. Үүний өмнөх үеийн судалгаанууд ихэвчлэн аль нэгэн дурсгалт газрын юм уу, ихдээ л гэхэд аль нэг бүс нутгийн ваар савны судалгаанд төвлөрч байсан бол Му Цзиньшань анх удаа пазырыкийн соёлыг бүхэлд нь хамарсан төдийгүй ангилал зүй, технологийн анализ, тоон ба чанарын олон төрлийн цогц судалгааг хийж чадсан нь энэ сэдвийг ихэд урагшлуулж судалгааны өнөөгийн түвшинг бүрэн илэрхийлж байна.

Монголын пазырыкийн соёлын ваар савны тухай тусгайлан судалсан бүтээл одоогоор үгүй байна. Монгол-Орос-Германы хамтарсан төслийн судлаачид Олон гүүрийн гол-6 ба 10 цогцолборын хэрэглэгдэхүүнийг судалж нийтлэхдээ нэг бүтэн ба хоёр хагархай ваарны амсрын хэсгийн гэрэл болон гар зургийг нийтэлсэн байдаг [Цэвээндорж, Молодин, Парцингер, 2016: 38, Зур. 34, 218].

Хэдийгээр оршуулгын дурсгалтай хамаагүй боловч Монгол Алтайд илэрсэн түрүү төмрийн үеийн анхны суурины ваар савны хэрэглэгдэхүүн онц сонирхолтой юм. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт байх Годон голын адгийн Шар Говь-4 сууринаас хүрэл болон түрүү төмрийн үеийн ваар савнууд илэрсэн нь хэлбэр зүйн хувьд тогтоогдсон боловч хэтэрхий жижиг болж бутарсан тул ваарны төрөл зүйлийг нь тогтоох боломжгүй харагдаж байна [Мерц, 2015; Степанова, Мерц, 2016].

Монголын түрүү төмрийн үеийн чандмань-сагилын соёлын ваар савны тухай судлаач Г.Мэнэсийн бичсэн тусгайлсан судалгаа [Мэнэс, 1985] байдаг нь хэдийгээр нэг соёл биш боловч нэгдүгээрт, нэгэн цаг үед холбогдоно, хоёрдугаарт, хөрш зэргэлдээх бөгөөд аль аль нь скифийн хэлбэрийн соёлын нийтлэгт хамаардаг тул бидний судалгаанд шууд хамааралтай юм.

**Эх хэрэглэгдэхүүн**

Одоогийн байдлаар Монгол Алтайн нуруунд буюу Баян-Өлгий аймгийн (нутагт) 21 оршуулгын цогцолборт 2005 оноос хойш малтан судлаад буй 50 булшны 40-өөс нь 68 ширхэг шавар ваар савыг илрүүлсэн байна. Үүнээс 22 буюу 32% нь бүтэн илэрсэн болон эвлүүлэн нааж сэргээн засварлах боломжтой байжээ (Хүснэгт 8). Мөн хэдийгээр зарим хэсэг нь үгүй болсны улмаас дутуу боловч 12 ваарыг сэргээн дүр төрхийг нь эвлүүлэн нааж босгосон байна. Ингэснээр 34 ваарны хэлбэр төрхийг харах боломжтой юм. Мөн зарим хэсгийг нь сэргээсэн 4 ваар байна. Харин үлдсэн 30 ваар хэлбэр төрхийг сэргээх боломжгүй хэт жижгэрч бутарсан байдалтай байна. Энэ бол тооны хувьд жинтэй төлөөлөл болох бөгөөд Монголын эртний ваар савны дотор зөвхөн Хүннүгийн ба чандмань-сагилын соёлын дараа орох томоохон цуглуулга гэж үзэж болно.

Монгол Алтайн пазырыкийн нүүдэлчдийн Бага Түргэний гол I, VI, Цэнгэл хайрхан I, III, V, Харганат IV, Сыргаль I, II, III, Хатуу I, II, III, Цагаан салаа буюу Олон нуурын гол гэсэн 6 үндсэн бүлэгт хамаарах 14 оршуулгын цогцолборын 38 булшны 30-аас нь 55 ширхэг ваар савны хэрэглэгдэхүүн илэрсэн юм. Тухайлбал, 2005-2013 онд Ц.Төрбат, П.Х.Жискар, Д.Батсүх нарын удирдсан Монгол-Францийн хамтарсан “Евразиа” төслийн хүрээнд Монгол Алтайн пазырыкийн соёлын нийт 38 булшийг малтан судалснаас Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Бага Түргэний гол, Харганатын гол, Сыргаль, Хатуу, Улаанхус сумын Цагаан салаа, Сагсай сумын Цэнгэл хайрхан зэрэг газарт малтан судласан 30 булшнаас 55 ваар илэрсэн байна [Төрбат, Батсүх, 2005: 15, 17, 19; Төрбат нар, 2006: 6, 7, Зур. 2: 8, 10, Зур. 7: 11, 12, Зур. 12: 14, Зур. 16: 17, 19, Зур. 20: 20, 22, Зур. 24; Төрбат, Батсүх, Батбаяр, 2008: 38, Зур. 33: 39, 41, Зур. 39: 42, 44, Зур. 45; Төрбат, Батсүх, Баярхүү, 2010а, 28, 34, 40, Зур. 22: 41, 43, 45, 49, Зур. 30: 51, 58, гар зур. 2: 60, гар зур. 4: 63, гар зур. 8: 65, гар зур. 10: 66, гар зур. 11; Төрбат, Батсүх, Баярхүү, 2010б, 12, 13, 18, 19, 22, 25, 46, 47, 52, 53, 67, 68, 72, 77, 90, 92, 93, 98; Төрбат, Батсүх, Баярхүү, 2011, 18, 20, 21, 24, 43, 45; Төрбат, Батсүх, Баярхүү, 2012, 47, 48, 50; Батсүх, Баярхүү, 2014, 27, 28, 30, 31, 34, 38, 39, 45].

Харин Цагаан салаа буюу Олон нуурын гол VI, Олон нуурын гол X, Билүүт II-1, Билүүт II-2, Шивээт хайрхан I, III, IV гэсэн 3 үндсэн бүлэгт хамаарах 7 оршуулгын цогцолборт ажилласан Монгол-Орос-Герман, Монгол-Америк, Монгол-Солонгосын хамтарсан судалгааны багуудын малтан судласан 12 булшны 10-аас нь 13 ваар сав илэрсэн байна. Тухайлбал, 2006 онд Монгол-

Орос-Германы хамтарсан экспедицийн малтсан 2 булшнаас 3 ваар [Цэвээндорж, Молодин, Парцингер, 2016: 17, 22, 38, 164, Зур. 218, 64, Зур. 34-1, 2], Монгол-Америкийн хамтарсан экспедицийн малтсан 3 булшны 2-оос нь 2 ваар [Fitzhugh, Kortum 2012: 27, 48, 96, Зур. 40; Баярсайхан, Эгиймаа, Бүрэнтогс, 2012, 29; Fitzhugh et al, 2013: 32, 36, Fig. 59], Монгол-Солонгосын хамтарсан экспедицийн малтсан 7 булшны 6-аас нь 8 ваар гарсан байна [Батболд нар, 2016: 11, 14, 24, 25, 30; Батболд нар 2017: 8, 9, 11, 12, 24, 25; Батболд нар, 2018: 21-23, 30, 32].

Монгол-Францийн судалгааны багийн судалсан 38 булшны ваар сав илэрсэн 30 булшны 17 булшнаас 1 ш, 9 булшнаас 2 ш, 2 булшнаас 3 ш, 1 булшнаас 4 ш, харин 1 булшнаас 10 ш буюу нийт 55 ширхэг ваар илэрсэн байна. Харин бусад судалгааны багийнхны малтсан 12 булшны 8 булшнаас 1 ш, 1 булшнаас 2 ш, 1 булшнаас 3 ш буюу нийт 13 ваар илэрсэн байна.

Дээрх ваар савны төрөл зүй, шинж чанар ба тоон үзүүлэлтийг хавсралт хүснэгтээс үзнэ үү (Хүснэгт 8).

**Нэр томьёо**

Пазырыкийн ваар савыг хэлбэрийн талаас ангилахад анхаарууштай чухал нөхцөл бол бараг бүх ваар бусадтай адилгүй хэлбэртэй юм. Судлаачид ч яг адил хэлбэр хэмжээтэй ваар таардаггүй болохыг тэмдэглэсээр ирсэн. Жишээлбэл, Катунь голын дунд урсгалын пазырыкийн соёлын булшнаас гарсан 313 ваарны хэрэглэгдэхүүн дээр ажилласан Н.Ф.Степанова зөвхөн нэг булшнаас гарсан ваарнууд л харьцангуй ижил хэлбэр хэмжээтэй байхаас бус адил олдвор огт таардаггүй болохыг тэмдэглэжээ [Кирюшин, Степанова, 2004: 25]. Монголын пазырыкийн ваар савны тухайд ч яг адил ажиглалт хийснээ энд тэмдэглэе. Тухайлбал, СЫР-II: 8-р булшнаас гарсан хоёр бутан хэлбэрийн сав харьцангуй төстэй хэмжээтэй төдийгүй зурмал хээтэй байсан жишээтэй.

Пазырыкийн ваар савнуудыг хэлбэрийн талаар ангилахад бэрхшээл учруулдаг дараагийн асуудал бол төрлүүд нь илэрхий ялгарсан бус хоорондын ялгаа нь нэлээд бүрхэг, нэг төрлөөс нөгөө төрлийн хоорондох завсрын шинжтэй ваарнууд олон байдаг явдал юм. Хэдийгээр дээр дурдсан төрлүүд байгаа нь илэрхий боловч зарим ваарыг чухам аль төрөлд хамааруулах нь нэлээд субъектив шинжтэй байдаг. Үүнтэй холбогдон нэр томьёог нь оноох асуудал ч тулгардаг байна. Пазырыкийн ваар савны судлалд хэлбэр төрх нь ойролцоо байдаг учир оросын уламжлалт ваар савны нэр томьёог авч хэрэглэсэн байдаг. Гэтэл нэг талаас хэлбэрийн

хувьд ойролцоо боловч яг ижил зүйл байхгүй бөгөөд нөгөө талаас оросын ваарны нэр томьёо ч өөрөө ээдрээтэй байдаг тул нэрийн оноолт дээр олон эргэлзээ будлиан байсаар байна [Степанова, 1998].

Гэхдээ пазырыкийн соёл судлаачдын хүрээнд ваар савны нэрийг оноохдоо бага зэргийн зөрөө гаргах боловч ерөнхийдөө нийтлэг байна гэж үзэв. Судалгааны бүтээлүүдийг шүүж үзэхэд нийт арав гаруй төрлийн ваар савыг оноон нэрлэсэн байна. Эдгээрээс хамгийн түгээмэл нь домбо, бутан, хотго, тогоо, аяга зэрэг юм. Харин Монголын пазырыкийн булшнаас зөвхөн домбо, бутан, хотго гурван төрлийн ваар сав илэрч олджээ. Доор эдгээрийг тодорхойлъё.

**Домбо.** Орос хэлний кувшин хэмээх үгийг монгол хэлэнд бид домбо хэмээн буулгаж байна. Монгол хэлний тайлбар толиудад домбо хэмээхийг “шингэн зүйл агуулах цоргогүй хараатай сав” хэмээн тайлбарласан байдаг [Болдхуяг, 2003]. Домбо гэсэн нэр томьёог археологийн судалгааны бүтээлүүдэд төдийлөн өргөн хэрэглэдэггүй. Бидний үзсэнээр чандмань-сагирын соёлын ваар савны судалгаандаа Г.Мэнэс кувшин буюу домбо гэсэн нэр томьёог хэрэглэсэн байдаг [Мэнэс, 1985]. Гэтэл ахуйн хүрээнд бол энэ үгийг өргөн хэрэглэдэг билээ.

Пазырыкийн соёлын домбо хэмээх вааран сав бол өндөр хүзүүтэй, бөмбөлгөн эх биетэй, хумигар ёроолтой сав юм. Домбоны эх биеийн голч нь амсрын голчоос илүү байх учиртай. Ёроолын голч нь харин амсрын голчоос бага байх ёстой.

Домбо бол пазырыкийн ваар савны хамгийн олон тоотой түгээмэл хэлбэр нь мөн боловч Алтайн бүс нутагт түрүү төмрийн үеэс өмнө үзэгдэж байгаагүй ваар савны шинэ хэлбэр юм [Кубарев, 1991: 59]. Эдгээр нь хэлбэрийн хувьд хоёр үндсэн дэд төрөлд хувааж байгаа нь: 1) бөмбөгөр эх биетэй бөгөөд шулуун босоо хүзүүтэй; 2) бөмбөлгөн юм уу илүү хавтгай эх биетэй, дотогшоо хотойсон хүзүүтэй болно [Марсадолов, 2004: 40]. Монголын пазырыкийн домбонууд ч яг ийм хоёр төрөлд хуваагдахаар байна.

Үүрэг зориулалтын хувьд домбо бол нарийн хүзүүтэй, уртлаг биетэй бөгөөд наамал, зурмал, ухмал хээгээр баялаг чимэглэсэн зэргээс үзэхэд голчлон шингэн зүйл хадгалах зориулалттай сав болох нь харагддаг.




**Хотго.** Хотго ваар Алтайн

түрүү скифийн үе буюу НТӨ IX-VII зуунд хамаарах маймир-бийкений соёлоос пазырыкийн үед уламжлагдсан бололтой. Орос хэлний горшок хэмээх үгийг бид монгол хэлэнд хотго хэмээн буулгаж байна. Монгол хэлний тайлбар толиудад хотго хэмээхийг “шавраар үйлдсэн ваар сав” гэхчлэн ваар савны ерөнхий нэр гэж ойлгогдохоор тайлбарласан байдаг [Болдхуяг, 2003]. Харин Монголын археологийн судалгаанд хотго хэмээхийг зөвхөн Хүннүгийн ваар савны тухайд хэрэглэж ирсэн уламжлалтай байна. Судлаачид уг төрлийн ваарыг “эх биеийн голчтой тэнцэхүйц том буюу задгай амсартай хотго [...] Булшнаас олдсон задгай амсартай дийлэнх хотго хэлбэрийн ваарны гадаргууд хөө ис тогтсон байдаг тул ийм ваарыг “тогоо” болгон ашиглаж байсан, эсвэл хуурай зүйл хадгалах зориулалттай хэмээн тайлбарладаг” хэмээн тодорхойлдог байна [Эрэгзэн, 2016].

Үүрэг зориулалтын хувьд хотго бол намхан хүзүүтэй, дэрвэгэр амсартай байхаас үзэхэд голчлон хоол боловсруулан чанах зориулалттай сав болох нь харагддаг. Гэхдээ бусад төрлийн хэрэглээг үгүйсгэж болохгүй юм. Шингэн болон хуурай зүйлийг хадгалах зориулалтыг энд дурдаж байна. Зарим хотго ваар наамал болон ухмал хээтэй байдаг.

**Бутан.** Орос хэлний кринка хэмээх үгийг бид монгол хэлнээ бутан хэмээн буулгаж байна. Монгол хэлний толиудад “амсар хумигар, цээл их, ёроолоороо шолдгор бөгөөд бумбагар ваар” хэмээн тодорхойлсон байдаг [Болдхуяг, 2003]. Бутан хэмээх нэр томьёог Хүннүгийн ваар савны судалгаанд хэрэглэхдээ: “харьцангуй жижиг амсар, нарийн хүзүүтэй бутан хэлбэрийн [...] жижиг амсар, нарийн хүзүүтэй бутан ваарыг хэлбэр төрхөд нь тулгуурлан шингэн зүйл хийх зориулалттай хэмээн үздэг байна” хэмээн тодорхойлжээ [Эрэгзэн, 2016].

Хүснэгт 1. Монголын пазырыкийн булшны ваар савны төрөл зүйл ба нэр томьёо

Нэр төрөл	Домбо	Хотго	Бутан
	Кувшин	Горшок	Кринка
Англи хэлээр	Jug	Crock	Vase
Зураг			

Хүснэгт 2. Хээнүүд

Төрөл \ Хэлбэр	Зурмал	Ухмал	Наамал
Долгион			
Зигзаг			
Цагариг ба хагас цагариг			
Гогцоо			
Угалз			
Спираль буюу эргүүлэг мушгираа			
Шудуун			
Цэг			
Дэгрээ			

Хэлбэрийн хувьд бутан ваар нь домбо ба хотго хоёрын дундын байрлалыг эзэлдэг. Тэд домбоноос илүү өргөн бөгөөд намхан хүзүүтэй, хүзүүнээс эх бие рүү шилжих өнцөг багатайгаараа ялгаатай. Хотгоноос ялгаатай нь илүү нарийхан биетэй, илүү хурц өнцөг бүхий хэлбэртэй, тийм ч өргөн биш хүзүүтэй байдаг.

Үүрэг зориулалтын хувьд бутан сав ихэвчлэн шингэн ба хуурай зүйлийг агуулах үүрэгтэй байсан бололтой. Бутан савыг ихэвчлэн наамал хээгээр бүтэн ороолгон чимэглэдэг. Цөөн заримыг нь амсрын доохон талд цувруулан хонхойлгосон үрлэн хээгээр чимэглэсэн байдаг. Зөвхөн бутан савнуудын дотор “чихтэй” ваар таарч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Нэг судалгаагаар домбо ба домбо хэлбэрийн савнууд нийт ваар савны 66,3%-ийг эзэлдэг байна [Степанова 1998: 139]. Ямар боловч домбо бол пазырыкийн ваар савны хамгийн түгээмэл хэлбэр гэдэг нь эргэлзээгүй бөгөөд Монголын хэрэглэгдэхүүн ч үүнтэй яг сайн нийцэж байна. Монголын 34 ваарны 18 буюу 53% нь домбоны төрөлд багтана. Бутан хэлбэрийн ваар сав 17,8% эзэлж байгаа бол Монголын жишээн дээр 10 буюу 29% эзэлж байна. Хотго ба хотго хэлбэрийн ваар сав 7,8% эзэлдэг бол Монголын жишээн дээр 6 буюу 18% болж байгаа юм. Пазырыкийн соёлын ерөнхий тоон үзүүлэлт ба Монголын пазырыкийн

тоон үзүүлэлт их бага хэмжээгээр зөрөөтэй байгаа нь зарим бодит учир шалтгаантай болов уу. Юуны өмнө Орос Алтайн булшнаас гардаг корчаг, банка, чайник зэрэг төрлүүд Монголоос илрээгүй байгааг дурдая. Нөгөө талаас дээр дурдсан төрөл зүйлийг оноох бэрхшээлтэй холбоотой.

### Хээ чимэглэл

Пазырыкийн ваар нь ерөнхийдөө Хүннүгийн ваарыг бодвол бүдүүн ширхэгтэй болхи хийцтэй. Гэсэн хэдий ч хээ чимэглэлийн хувьд Хүннүгийн үеэс илүү баялаг бөгөөд олон төрөлтэй юм. Жишээлбэл, зурмал хээ Хүннүгийн үед таардаггүй. Харин Пазырыкийн ваар савны гадаад хэлбэр хэв маяг нь Чандмань-Сагилын ваар савтай хэлбэр хийц төдийгүй хээ чимэглэл ч ижил төстэй байгаа нь тэдгээрийн хоорондын соёлын харилцаа холбооноос хамаарч байсан болов уу [Мэнэс, 1985]. Мөн тэд нэг цаг үед зэрэгцэн оршиж байсан тул эдийн болон соёлын харилцан хамааралтай байсныг харуулах нэгэн баримт болно.


Монголын пазырыкийн ваар савны хээ чимэглэлийг 3 хэлбэрийн 9 төрөлд хувааж үзэж болно (Хүснэгт 2). Хээ бүтээх хэлбэрүүд нь: зурмал, ухмал, наамал гэсэн 3 хэлбэрт хуваагдана. Харин хээний төрлүүд нь бидний тогтоосноор 9 төрөл байх боловч ихэнхдээ хамт хоршиж нэгэн чуулбар хээг бүтээж байгаа бөгөөд заримдаа хэлбэр дамжин хоршсон хээний чуулбар ч тохиолддог.

*Зурмал хээ.* Зурмал хээг домбо саван дээр тавьдаг байжээ. Одоогоор пазырыкийн соёлын хүрээнд будмал хээгээр чимэглэсэн нийт 50 гаруй вааран сав илрээд байна [Му 2023: 182]. Ийм хэлбэрийн хээтэй ваар савнууд Алтайн бүс нутагт пазырыкийн соёлоос өмнө гарч байгаагүй тул гаднаас ирсэн нөлөөлөл гэдэг нь ойлгомжтой байдаг. Ялангуяа Шинжаанд хүрлийн үеэс будмал хээтэй ваар савны хөгжингүй соёл байсныг харгалзан үзвэл пазырыкийн соёлын гадаад хэлхээ холбооны нэгэн шинэ өнцөг харагдах юм.


В.Д.Кубарев ийм хээг 3 бүлэгт хуваасан нь: 1) спираль юм уу чөлөөтэй буржгар, 2) могой хэлбэрийн буюу долгио ба зигзаг хээ, 3) налуу зураасан хээнүүд: үүний дотор уужуу муруй, зигзаг-уулан хээ, гогцоо хээ зэрэг орно [Кубарев 1990: 34-36]. Манай хэрэглэгдэхүүнд байгаа зурмал хээнүүд мөн 3 төрөлд багтах нь: 1) долгион; 2) цагариг ба хагас цагариг; 3) спираль буюу эргүүлэг мушгираа хээнүүд болно (Хүснэгт 3). Зурмал хээний төрөл зүйлийн хувьд Монголын пазырыкийн ваар сав бусдаас онц ялгарахгүй байна.

Н.Ф.Степанова харин Орос Алтайн түрүү төмрийн үеийн ваар савны наад зах нь 17% ийм

Хүснэгт 3. Зурмал хээний төрлүүд



Хүснэгт 4. Ухмал хээний төрлүүд



будмал хээтэй болохыг тогтоожээ [Кирюшин, Степанова, 2000; Кирюшин и др., 2003: 100-103]. Гэхдээ Му Цзиньшаний хийсэн хамгийн сүүлчийн судалгаагаар будмал хээтэй ваар нийт пазырык ваарны дөнгөж 9% болж байгаа ажээ. Монголын 68 ваарны ердөө 5 нь зурмал хээтэй байгаа нь 7% болж байгаа нь ч нийт пазырыкийн ваар савны үзүүлэлтэй ойролцоо байна.

Пазырыкийн будмал хээ өнгө ба хээний хувьд хоёр үндсэн бүлэгт хуваагдаж байна. Эхний бүлэг нь шараас улбар шар хүртэл олон хувилбартай бөгөөд ваарны гадарга дээр багс мэт зүйлээр таслал, гогцоо хэлбэрийн хээ дүрсэлсэн байдаг. Ердөө 6 ширхэг ийм хээний жишээ бүртгэгдээд байна. Дараагийн бүлэг нь хар өнгийн будгаар гогцоорсон ба хугарсан хээнүүдийг дүрсэлжээ. Ийм ваар нийт 48 ширхэг байна [Му, 2023: 185-186]. Монголын зурмал хээнүүд бүгд хар өнгийн будгаар зурагдсан байна.

Будмал хээний үндсэн хэлбэр нь угалзарсан, гогцоорсон, хугарсан байдалтай байх тул В.Д.Кубарев ийм төрлийн хээг могойг дүрсэлсэн гэж үзээд газар доорх буюу үхэгсдийн ертөнцийг бэлгэдэж буй юм хэмээн дүгнэжээ. Иймээс тэрээр будмал хээтэй ваарнууд бол онцгой тахилгын суулга хэмээн үзэж байна [Кубарев, 1990].

Му Цзиньшань пазырыкийн будмал хээний уламжлалыг Шинжааны хүрлийн үеийн олон соёлтой харьцуулан үзээд янбулакын соёлтой хамгийн ойр бөгөөд гарал үүслийн холбоотой бололтой гэж үзсэн байна [Му, 2023: 183]. Дашрамд дурдахад тэрээр пазырыкийн ваар савны өөр нэг онцлог төрөл болох “чихтэй” ваарнуудыг мөн янбулакын соёлын нөлөөгөөр үүссэн гэж үздэг.

Ухмал хээ. Ухмал хээг домбо ба хотго вааран дээр тавьдаг байжээ. Ийм хээг тавихдаа ваарны эх бэлдэцийг босгосны дараа бүрэн хатахаас нь өмнө дахин норгож байгаад хүссэн өргөнтэй зураасыг саваагаар сараачин зурж гаргадаг. Хээнүүд нь

төрөл зүйлийн хувьд баялаг.


Манай хэрэглэгдэхүүний дотор 5 төрлийн ухмал хээ чимэглэл бүртгэгдсэн байна (Хүснэгт 4). Үүний дотор зигзаг буюу уулан хээ хамгийн түгээмэл бол гогцоо угалзнууд түүний дараа орно. Харьцангуй ховор дүрслэлийн тоонд БИЛ-II: 2-1 ваарны шавааралдуулсан цэгнүүд (Хүснэгт 4-6) ба ШХ: 7-2 ваарны дээрээ иштэй уруугаа харсан навч мэт дүрслэл (Хүснэгт 4-5) орж байна. Шивээт хайрханы дээрх ваар бол ухмал хээг наамал хээтэй хослуулан үйлдсэн сонирхолтой төлөөлөл болдог.

Энэ төрлийн хээний дотор тусгайлан дурдах учиртай зүйл бол ихэвчлэн амсрыг дагуулан бүтэн тойруулж тавьсан байдаг хонхойлгосон үрлэн хээ юм. Энэ бол пазырыкийн соёлын хүрээнд нэлээд түгээмэл зүйл ажээ.

Ухмал хээтэй ваарнууд дотор ШХ-III: 7-р булшны №2 домбон ваар пазырыкийн соёлын хүрээнд харьцангуй ховор өвөрмөц хээтэй юм (Хүснэгт 4-5). Амсрын дагуу үрлэн хонхорхойгоор чимэглээд түүнээс дооших бүс талбайг доороо навчин хэлбэртэй дээрээ дан болон хоёр иштэй дүрсээр чимэглэжээ. Навчны дотор талыг ташуу зэрэгцээ зураасуудаар дүүргэсэн байна. Сонирхолтой нь үүнтэй яг ижил гэж хэлж болох домбо бол Орос Алтайн өмнөд хэсгийн Кок-су оршуулгын цогцолборын 10-р булшны №5 дугаартай ваар юм [Сорокин, 1974: Рис. 3: 5]. Хэдийгээр энэ хоёр ваар хээний хувьд бараг ялгаагүй адилхан боловч хэмжээний хувьд бага зэргийн ялгаатай юм. Кок-сугийн домбо 19,4 см өндөртэй, 6 см амсрын голчтой, 11 см бөөрний голчтой [Сорокин, 1974: Таб. 11] байгаа бол ШХ III: 7-2 дугаартай ваар 23 см өндөртэй, 11 см амсрын голчтой, бөөр нь 12 см голчтой юм.

Кок-су дурсгалаас илэрсэн өөр нэгэн ижилсэх ваар бол 27-р булшнаас гарсан бутан хэлбэрийн ваар болно [Сорокин 1974: Рис. 8: 4, 12: 4]. Энэ ваарны хээний үндэс нь дотроо ташуу зураасуудтай навчин хэлбэрийн олон давтагдсан хээ болж байна. Түүгээр зогсохгүй ваарны

Хүснэгт 5. Наамал хээний төрлүүд



гадаргын үлдсэн талбайг мөн урт богино ташуу зураасаар дүүргэжээ.

СЫР-II: 8-р булшнаас гарсан №4 ба 10 дугаартай хоёр ваар өвөрмөц баялаг хээ чимэглэлээр ялгарч байна. Энэ хоёр ваарны хээ үндсэндээ ижил бөгөөд хэрэглэсэн хээний төрөл зүйл нь адил (Хүснэгт 4: 2 ба 3). Гэвч №4 дугаартай вааранд 3 давхар эгнээ хээ тавьсан бол №10 дугаартай вааранд 4 давхар эгнээ хээ тавьжээ. Эдгээр хээ нь зигзаг, босоо иштэй гогцоо ба хөндлөн зураас зэрэг болно. Дээр дурдсан Кок-су дурсгалд энэ хоёртой ижилсэх хээтэй ваарнууд хэд хэд гарсан нь зүй ёсоор сонирхол татаж байна. Юуны өмнө 10-р булшны вааранд 3 давхар зигзаг хээ тавьсан [Сорокин, 1974: Рис. 3: 6], 21-р булшны вааранд хөндлөн зураас дээр цуварсан гогцоо хээ тавьсан [Сорокин, 1974: Рис. 6: 8], харин 31-р булшны вааранд 4 давхар эгнээ хөндлөн зураас ба тэдгээрийн хооронд 3 эгнээ зигзаг хээ тавьжээ [Сорокин, 1974: Рис. 10: 5]. Ерөнхийдөө Сыргалийн булшны хоёр ваарны хээ ба Кок-сугийн булшны гурван ваарны хээнүүд чуулбарын хувьд яг ижил биш боловч хээний хувьд ижил байгаа нь дээрх хоёр дурсгалын ваар савыг нэг ваарчин хийсэн юм биш байгаа хэмээн таамаглахад хүргэж байна.

Ийм төрлийн ухмал хээг цааш нь ухааж хөөвөл пазырыкийн соёлын бусад дурсгалуудаас гадна ойр холын хөрш соёлоос ч илэрч байна. Хамгийн ойрын жишээ бол Чандманий 11-р булшнаас гарсан нэгэн вааранд олон эгнэсэн хөндлөн зураас ба доошоо хошуурсан гурвалжин хээ буюу зигзаг хээний нэг төрөл байна [Novgorodova et al, 1982: Abb, 11: 6b]. Дараагийн нэгэн жишээ бол Тувагийн Хэндэрэг голын чандмань-сагилын булшнаас гарсан вааранд гурван давхар хөндлөн зураас ба зигзаг хээ тавьсан байна [Маннай-Оол 1970: Рис. 14: 5]. Харин хамгийн холын жишээ бол Баруун тал нутгийн сарматын соёлын ваар савны дотор хөндлөн зураас ба зигзаг хээний хослолууд тогтвортой чуулбар үүсгэж байдаг ажээ [Смирнов, 1964: Рис. 60: 6, 61: VIII, 62. III г.м.]. Энэхүү хээний чуулбар хүрлийн үеэс гаралтай бөгөөд

сарматууд нутгийн уугуул соёлоос өвлөн авсан байдаг ажээ. Дашрамд дурдахад пазырыкийн вааранд олон таардаг амсрын доор цувран хээлсэн үрлэн хонхорхойнууд мөн сарматын ваар саванд түгээмэл тохиолддог нь соёлын харилцан нөлөөллийн нэг жишээ байж мэднэ.

Ухмал хээний өөр нэгэн сонирхолтой чуулбар бол Билүүт II, 2-р булшны шулуун хүзүүтэй домбон дээрх зигзаг ба шигүү цэгэн хээ юм (Хүснэгт 4: 6). Үүнтэй ижилсэх олдвор Орос Алтайн Сайлюгемийн (монг.: Сийлхэм) нурууны орчмын Барбургазы-I пазырыкийн оршуулгын цогцолборын 11-р булшнаас гарсан [Кубарев, 1992: Рис. 15: 7] нь ховорхон төслөг хэрэглэгдэхүүн (аналог) болж байна.

*Наамал хээ.* Наамал хээ бол пазырыкийн ваар савны түгээмэл нэгэн төрөл юм. Орос Алтайн хэрэглэгдэхүүн дотор 21% нь наамал хээтэй байжээ [Кирюшин, Степанова 2004: 40]. Наамал хээний дотор гогцоо, спираль буюу эргүүлэг мушгираа, шулуун, дэгрээ гэсэн 4 төрөл бүртгэгдсэн байна (Хүснэгт 5). Гогцоо хээ ба түүний өөр нэгэн хувилбар болох спираль голлох төрөл нь болдог бөгөөд зурмал хээний төрөл зүйлтэй адилсаж байгаа билээ.

Наамал хээний тусгай төрөл болохгүй боловч ижил техникээр хийсэн нэгэн бүтцийн элемент бол ваарны биеийг бүхэлд нь ороож тавьсан наамал товгор бүслүүр юм. Үүнийг судлаачдын зарим нь хээний нэг төрөлд хамруулдаг [Кирюшин, Степанова, 2004: 40]. Наамал бүслүүр ихэвчлэн ганц байх бөгөөд тэр нь хүзүүгээр тавигдсан байх боловч хоёр ба түүнээс олон бүслүүр ч байдаг. Жишээлэхэд БИЛ-II: 2-2-1 вааранд хүзүүнд дөрвөн эгнээ, мөрөнд гурван эгнээ байх төдийгүй бөөрний дөрвөн талд тус бүр нэг спираль наамал хээ тавьжээ (Хүснэгт 5-4). Ийм бүслүүрийн гадарга нь гөлгөр юм уу хөндлөн хэрчлээс тавьсан байдаг. Зарим төрлийн наамал хээ, түүний дотор дэгрээ хээн дээр ийм хөндлөн хэрчлээс татсан жишээнүүд манай хэрэглэгдэхүүн дотор бий (ХАР-IV: 2-4). Орос Алтайн хэрэглэгдэхүүнээс

Хүснэгт 6. Чихтэй ваарнууд. 1 – ХАТ-III: 6-5 дугаартай ваар, 2 – ХАТ-II: 1-12 дугаартай ваар, 3 – ХАТ-I: 1-18 дугаартай ваар, 4 – ХАТ-III: 6-3 дугаар ваар






харахад ийм наамал бүслүүр бүхий ваарны ихэнх нь Өмнөд Алтайгаас илэрсэн (80%) байдаг байна (мөн тэнд).

Наамал хээний дотор хамгийн түгээмэл нь гогцоо юм уу спираль хээ юм. Ийм хээ пазырыкийн бусад дурсгалууд дотор олон тохиолддог [Кубарев, 1992: 43] гадна хөрш археологийн соёлуудад ч мөн таарч байна. Жишээлбэл, Чандманий 47-р булшнаас гарсан нэгэн вааранд гогцоорсон наамал хээ тавьсан [Novgorodova et al, 1982: Abb. 65g] нь Монголын пазырыкийн БИЛ-2 булшны ваарны хээтэй (Хүснэгт 5: 5) ихэд төстэй юм. Өөр нэгэн жишээ бол Тувагийн Казырган оршуулгын цогцолборын 18-р булшнаас гарсан ваарны бөөрөнд дөрвөн наамал спираль хээ тавьсан нь [Маннай-Оол, 1970: Рис. 14: 6] БИЛ-II: 2-1 булшны ваарныхтай адилхан байна. Түүгээр зогсохгүй Минусын хотгорын Таштыкийн соёлын булшнаас гарсан нэгэн вааран хүзүүний хөндлөн бүслүүрээс доошоо зүүгдсэн наамал спираль ч дээрх дүрслэлийг санагдуулж байна [Вадецкая, 1986: Таб. IX: 43].

“Чихтэй” ваар. Пазырыкийн соёлын ваар савны дотор онцгой зүйлийн чимэглэл, бүтцийн бүрдэл хэсэг бол “чихтэй” ваар юм. Орос Алтайн “чихтэй” ваар савнуудыг хоёр төрөлд хуваадаг нь: 1) хүзүүний захаар байрласан хос гогцоо хэлбэрийн жижиг бариултай ваар, 2) хүзүүн дээр гаргасан хос нүх ба түүний дээр нааж хийсэн “хөмсөг” мэт хагас дугуй товгортой ваар болно [Кубарев, 2001: 126]. В.Д.Кубаревын үзэж байгаагаар 1-р төрөл буюу бодит бариул “чихтэй” ваар нь дууриамал “хөмсгөн” чимэглэлтэй ваарнаас арай илүү эртнийх болох байна. Ингэхдээ бодит чихтэй ваар нь алс баруун зүгийн Ижил мөрөн, Уралын нуруунаас нааш ирсэн харь гаралтай зүйл бөгөөд Обь орчмын кулайн соёл, магадгүй Долоон усны сака нарын соёлоос шууд нөлөөлсөн зүйл бололтой хэмээн үзжээ [мөн тэнд: 126-127]. Гэхдээ пазырыкийн зүүн талын хөрш чандмань-сагилын соёлын булшнаас бодит чихтэй ваарнууд олон гардгийг харгалзан үзэх хэрэгтэй болов уу. В.Д.Кубарев гуай нөгөөх 2-р төрлийн ваарыг нь орон нутгийн гаралтай бөгөөд бүр хожуу хүрлийн үеийн карасурын соёлоос эхлээд түрүү төмрийн үеийн хөрш чандмань-сагилын ба большевичеречений соёлд түгээмэл таардаг хэмээн үзжээ [Кубарев, 2001: 127]. Нөгөө талаар Му Цзиньшань пазырыкийн соёлын “чихтэй” ваарыг Дорнод Шинжааны янбулакын соёлын нөлөөгөөр үүссэн гэж үзсэн байгааг харгалзан үзүүштэй боловч хангалттай нотолгоотой биш байна [Му, 2023: 183].

Монголын хэрэглэгдэхүүн дотор 4 ш “чихтэй”

Хүснэгт 7. Монголын пазырыкийн ваар савны төрөл зүйн схем



ваар гарсан нь бүгд хотго хэлбэрийн вааранд хамаарна. Чихний хэлбэр нь үндсэндээ нэг хэлбэртэй байна (Хүснэгт 6). Энэ нь нуман буюу “хөмсгөн” хэлбэртэй товгор чих юм. Хос чихийг амсрын доор гаргах боловч ХАТ-III: 6-р булшны №5 вааранд арай доохон талд нь хүзүүний орчим чихийг гаргажээ. Мөн ХАТ-II: 1-р булшны №12 вааранд чихний яг доод хэсгээр ваарны хүзүүг бүтэн ороосон эрчлээстэй товгор хүзүүвч тавьсан байна. Гурван ваарны чихний дотор талын дээд хэсэгт нэвт нүх гаргасан байдаг нь оосорлож зүүх зориулалттай байсан болов уу. Харин ХАТ-III: 6-3 вааранд ийм нүх гаргаагүй ажээ.

Энэ ваарууд бүгд Цэнгэл сумын нутаг Бага Хатуугийн голд буй Хатуу I-III гэсэн гурван оршуулгын цогцолбороос гарсан хэрэглэгдэхүүн юм. ХАТ-III оршуулгын газрын 6-р булшинд хоёр хүнийг оршуулсан байсан бөгөөд энэ булшнаас 2 ш чихтэй ваар нь илэрчээ. Бусад нь нэг хүний оршуулгаас гарсан байдаг.

#### Ангилал

Ваар савны нэр төрлийг тогтоож, хээ чимэглэлийг ангилсны дараах чухал алхам бол хэлбэрийн ангилал юм. Пазырыкийн ваар

савны олон янзын ангилал байгаагаас хамгийн сүүлчийнх нь гэхэд 600 гаруй савыг 143 төрөл болгон ангилсан байна [Му, 2023: 122-145]. Тэдгээрийн 43 төрөл нь ердөө ганц ширхэг ваараар төлөөлүүлж байгаа [Му, 2023: 146] нь ангилал зүйн хувьд ач холбогдолтой эсэх нь эргэлзээ төрүүлэхээр сэтгэгдэл төрж байгааг дурдая.

Монголын пазырыкийн ваар савыг бид 3 төрөл, 5 дэд төрөлд хуваан авч үзэв. Эдгээрийг доор тус бүрд нь авч үзье.

**I төрөл-Домбо.** Судалгаанд авч үзсэн 34 бүтэн ба хэлбэр төрхийг нь сэргээн харах боломжтой ваарны 18 нь домбоны төрөлд багтаж байна. Домбоны хэлбэр төрхийг дээр тодорхойлсон. Эдгээр нь 2 дэд төрөлд хуваагдана (Хүснэгт 7: I).

**I-1 дэд төрөл.** Дэлбэгэр амсартай домбо. Гадагш дэлбийсэн эгц амсартай, урт хүзүүтэй, бөмбөлгөн эх биетэй, хумигар ёроолтой ваар болно. Амсын голч нь ёроолын голчоос их байдаг тул дээрх дэд төрлөөс ялгарна. Энэ төрлийн ваар Монголын пазырыкийн хэрэглэгдэхүүн дотор хамгийн олон нь буюу 15 ширхэг байгаа нь нийт тооцоонд оруулсан ваарны 44% болж байгаа юм. Тархалтын хувьд хамгийн өргөн бөгөөд судалгаанд хамрагдсан бараг бүх дурсгалт газраас илэрсэн. Хээ чимэглэлийн хувьд мөн л баялаг бөгөөд зурмал, ухмал, наамал бүх төрлийг ашигласан. Хэмжээний хувьд хамгийн том ваарнууд энэ төрөлд хамаарна. Хэмжээний хувьд маш их хэлбэлзэлтэй бөгөөд хамгийн өндөр домбо (ОГГ-Х: 1-5) нь 36,7 см өндөртэй, 10,2 см амсын голчтой, 23,8 см бөөрний голчтой байна. Харин хамгийн жижиг (ХАР-IV: 1-7) нь 11,9 см өндөртэй, 5,2 см амсын голчтой, 7,7 см бөөрний голчтой байна (Хүснэгт 7: I-1).

**I-2 дэд төрөл.** Шулуун хүзүүтэй домбо. Эгц босоо хүзүүтэй, босоо амсартай, бөмбөлгөн эх биетэй, хумигар ёроолтой ваар. Ёроолын голч нь амсын голчоос их байдаг онцлогтой. Ийм ваар ердөө 3 ширхэг байгаа нь БТГ-VI: 13-4; ХАР-IV: 1-9; БИЛ-I I: 2-1 дугаартай олдворууд болно. Хэрэв БТГ ба ХАР дурсгалын ваарнууд элдэв хээ чимэглэлгүй нүцгэн гадаргатай байгаа бол БИЛ дурсгалын ваар наамал ба ухмал хээгээр хослуулан чимэглэсэн гоёмсог эдлэл байна. Хэмжээний хувьд харьцангуй жигд хэмжээтэй бөгөөд хамгийн том нь 21,5 см өндөртэй, 6,6 см амсын голчтой, 18,5 см бөөрний голчтой байна. Энэ үзүүлэлтээрээ дэлбэгэр амсартай домбоны дундаж хэмжээтэй ойролцоо юм (Хүснэгт 7: I-2).

**II төрөл – Бутан.** Манай хэрэглэгдэхүүн дотор 11 ваар энэ төрөлд хамаарна. Харьцангуй богино хүзүү ба ихэвчлэн эгц босоо амсартай, эх бие нь цүдгэр бөмбөлгөнөөс шувтан хүртэл, ёроол нь хумигар байдалтай. Юуны өмнө энэ төрлийн зарим

ваар савыг домбоноос ялгахад амаргүй гэдгийг дурдах нь зүйтэй. Гэхдээ домботой харьцуулахад илүү бахим бөгөөд намхан биетэй байдаг. Мөн амсар ба ёроолын голч ихэвчлэн адил хэмжээтэй байдаг. Түүнчлэн хүзүүгээр бүтэн ороосон товгор хүзүүвч юм уу эсвэл “чихтэй” байдаг нь гол онцлогууд болно. Пазырыкийн бусад ваар савны төрлийн адилаар дотроо яг ижил стандарт хэлбэр хэмжээ байхгүй, маш олон хувилбартай. Товгор хээ, хүзүүвч, чих, үрлэн сувсаар чимэглэсэн байдаг.

Тархалт нь өргөн дэлгэр бөгөөд Бага Түргэний гол, Харганат, Хатуу, Билүүт, Шивээт хайрханы дурсгалуудаас илэрсэн тул Монголын нийт пазырыкийн дурсгалуудад нийтлэг тархацтай гэж хэлж болно.

Үүрэг зориулалтын хувьд ийм төрлийн ваар савыг ширээний ваар гэж үзэж олно. Шингэн зүйлсийг хадгалах, ширээнд хэрэглэх зэрэгт голлон ашигладаг нь харьцангуй нарийн хүзүү ба жижиг хэмжээнээс харагдаж байна. Дотор нь хоёр дэд төрөлд хуваана (Хүснэгт 7: II)

**II-1 дэд төрөл.** Товгор хүзүүвчтэй бутан сав. Нийт 6 ваар энэ дэд төрөлд хамаарна. Товгор хүзүүвчийг ихэвчлэн хүзүүнд, мөн заримдаа мөрөнд тавьсан байдаг. Хэмжээ нь нэлээд ялгаатай бөгөөд хамгийн том нь 23 см өндөртэй бол хамгийн жижиг нь 17,3 см өндөртэй байна.

**II-2 дэд төрөл.** Чихтэй бутан ваар. Энэ төрлийн ваарны талаар дээр тодорхой өгүүлсэн.

**III төрөл – Хотго.** Нийт 6 ширхэг буюу нийт судалгааны хамруулсан ваарны 7,8% энэ төрөлд хамаарч байна. Богино хүзүү, хавчигдуу эх бие, босоо амсартай. Амсын голч нь ёроолын голчоос их байдаг. Хэлбэрийн хувьд нэлээд олон хувилбартай (Хүснэгт 7: III).

Бага Түргэний гол, Цэнгэл Хайрхан, Сыргаль зэрэг дурсгалуудаас хотго хэлбэрийн ваар илэрчээ. Эдгээрийн дотор СЫР-II: 8-р булшнаас нэлээд төстэй хоёр ваар гарсан бөгөөд уг оршуулга хүүхдийнх байсан тул оршуулгад дагалдуулсан ваарны хэмжээ нь хүний нас хүйстэй холбоотой байсан болов уу хэмээн таамаглах үндэслэл болдог.

Хотго ваарнуудыг олон төрлийн хээгээр чимэглэдэг дотор амсын доохон талаар бүтэн ороож гаргасан үрлэн хонхорхой, хүзүү ба мөрийг бүтэн ороосон наамал тууз, эсвэл бүр олон дүрсээс бүтсэн ухмал хээний чуулбар ч тохиолддог.

Хэмжээ нь бүрэн хэмжих боломжтой 3 ваарны хамгийн том нь 17,6 см өндөртэй, 8,2 см амсын голчтой, бөөр нь 12 см голчтой байна. Нөгөө хоёр хотго ваар ч ойролцоо хэмжээтэй юм.

Үүрэг зориулалтын хувьд гал тогооны сав гэж үздэг бөгөөд хоол чанаж болгох, савлаж хадгалах



Зураг 1. Харганат-IV дурсгалын 2-р булшны 4 дугаартай домбон ваар

зэрэг олон үүрэгтэй болов уу. Гэхдээ хэмжээний хувьд харьцангуй жижиг ваарнууд энэ төрөлд багтаж байгаагаас харахад хоол идэх явцад хэрэглэдэг ширээний ваарнууд ч энэ төрөлд багтаж байна. Манай ангилал хэлбэр ба хэмжээг голлон барьсан учир хэрэглээний хувьд олон төрлийн ваар нэг төрөлд багтсан байхыг үгүйсгэхгүй.

### Хэрэглээ

Пазырыкийн булшнаас гарч байгаа ваар савны ихэнхийг, ялангуяа домбо ба бутан хэлбэрийн ваарыг ахуйн хүрээнд хэрэглэж байгаагүй, зөвхөн оршуулгад зориулж хийсэн “сакраль” ариун нандин бэлгэдлийн шинжтэй хэмээн үздэг. Пазырыкийн оршуулгын ба суурингийн дурсгалуудаас гарч буй ваар савны төрөл зүйл огт өөр буюу суурингуудаас домбо ба бутан бараг гардаггүй байдал нь дээрх дүгнэлтийг батлах нэгэн нотолгоо болдог байна [Кубарев, 2001: 126; Кубарев, Шульга, 2007: 59]. Суурингуудаас зөвхөн вааран тогоо, хотго, аяга зэрэг төрлийн ваар савнууд гардаг. Сонирхолтой нь яг ийм төрлийн ваар савны үлдэгдэл хагархайнууд пазырыкийн булшны дараас чулууны дээрээс болон дундаас нь олддог ажээ [Кирюшин, Степанова, 2004: 42]. Иймээс хотго болон бусад энгийн хийцтэй жижиг хэмжээтэй ваарнууд жинхэнэ өдөр тутмын хэрэглээнд байжээ хэмээн дүгнэж болно.

Хэрэв пазырыкийн хүн амын цөмийг Алтайн ууланд гаднаас нүүдэллэн ирсэн гэж үзвэл тэдний авч ирсэн соёлын цөм эд зүйлийн нэг нь домбо хэлбэрийн ваар сав байсан бөгөөд орон нутгийн

ваарны хэлбэрээс эрс ялгардаг тул шинээр ирэгсэд өөрсдийн унаган соёлын илэрхийлэл хэмээн эрхэмлэн үздэг байж болно. Харин түрүү скифийн үе буюу Орос Алтайн хувьд бийкен-майэмирийн үед булшинд ваар сав дагалдуулдаггүй уламжлалтай байсан [Кубарев, Шульга, 2007: 58] тул орон нутгийн уламжлалт хотго, вааран тогоо болон аяга зэрэг төрлийн ваарнууд огт оршуулгын зан үйлийн хэсэг болдоггүй байжээ. Ийм нөхцөлд пазырыкийн булшнаас зөвхөн домбо ба бутан зэрэг харь гаралтай ваарнууд давамгайлж байгаа нь гайхмаар зүйл биш болов уу.

Пазырыкийн домбо том хэмжээтэй, урт хүзүүтэй, хумигар ёроолтой учир, нэг талаас хүнд нүсэр, нөгөө талаас тогтвор муутай юм. Ийм ваар сав нүүдлийн мал аж ахуйн орчинд тохиромж муутай нь илэрхий бөгөөд судлаачид ч удаа дараа дурдаж байжээ. Тиймээс удаан хугацаанд суурин байдаг өвөлжөөнд хүнс хадгалах зорилгоор ашигладаг байх боломжтой. Өвөлжөөний удаан хугацаанд суудаг сууцтай бүтэц, хэлбэрийн хувьд холбоотой байж болох дүгнэлт бунханд өвөлжөөний ваар сав болох домбыг тавьдаг байсан бололтой гэсэн таамаглал байдгийг тэмдэглэе [Кубарев, 1991: 59]

Монголын пазырыкийн булшнаас гарсан ваар сав дотроос нэг олдворын дотор талын тунадсанд химийн шинжилгээ хийсэн тохиолдол байгаа нь Харганат-IV дурсгалын 2-р булшны №4 дугаартай ваар болно (Зураг 1). Ваарны дотор талын өнгөрөөс дээж аван Франц улсын Н.Гарниэрийн лабораторид шинжлэн үзэхэд амьтны гаралтай өөх тос, сүүн бүтээгдэхүүн холилдсон байсан бөгөөд удаан хугацаагаар халааж байсан шинжтэй байна [Laboratoire Garnier, 2010]. Уг ваар 17 см өндөртэй, амсрын голч нь ердөө 6,4 см жижиг хэмжээтэй байгаа нь цагаан идээ боловсруулан хэрэглэхэд тохиромжгүй байгааг анхааран үзэх хэрэгтэй. Үүнийг чухам ямар зүйлийн идээ байсныг шууд хэлэхэд бэрхтэй боловч шимийн архи байсан бололтой гэсэн таамаглал бий.

Дээрх жишээ бол оршуулгын ёслолд зориулж жижиг домбонд өөх төс, цагаан идээний зүйл хийж тавьсан байж болох хэдий ч түүнийгээ удаан хугацаанд халааж хэрэглэсэн байсан нь өдөр тутмын амьдралд хэрэглэж байсан ваар болов уу хэмээн үзэхэд хүргэж байна. Гэхдээ домбо зэргийг өдөр тутмын амьдралд огт хэрэглэдэггүй байсан хэмээн үзэж болохгүйтэй адил уг домбонд бодит амьдрал дээр идээ цагаа сөгнөж байсныг үгүйсгэж чадахгүй юм.

### Дүгнэлт

Энэ өгүүллийн хүрээнд анх удаа Монголын пазырыкийн булшнаас гарсан ваар савны

судалгааны хэдэн асуудлыг тусгайлан авч үзлээ. Эдгээр асуудал нь ерөнхийдөө ангиллын эргэн тойронд төвлөрсөн бөгөөд ваар савны үйлдэх технологи, он цагийн асуудлыг хөндөөгүй хэрэглээний асуудлыг товч авч үзлээ. Энэхүү гурван асуудлыг хөндөн судлахгүйгээр аливаа соёлын ваар савны судалгааг бүрэн төгс хийсэн гэж үзэх аргагүй билээ.

Хэдийгээр бидний гарт дөнгөж 68 ваар савны зүйл, түүнээс 34 ваарыг их бага хэмжээгээр сэргээн харах боломжтой байсан боловч Монголын пазырыкийн соёлын ваар савны үндсэн төрхийг тодруулах боломжтой гэж үзсэн билээ. Энэ нь тооны хувьд цөөн мэт боловч Монголын өвөг ба түрүү түүхийн дотор Хүннүгийн ба чандмань-сагилын соёлын дараа орох чухал цуглуулга болж байна.

Пазырыкийн ваар сав хөрш чандмань-сагилын соёлын ваар савтай төрөл зүйл, хэлбэр хэмжээний хувьд ижилсэх зүйл багагүй байгаа нь скиф-сибирийн соёлын ертөнцийн хүрээнд хэвийн зүйл болов уу. Мөн Долоон усны газрын сака нарын соёлын ваар сав, түүний дотор том домбо бол пазырыкийн соёлын нөлөөгөөр гарч ирсэн байх үндэстэй [Кубарев, 1991: 60]. Пазырык ба чандмань-сагилын соёлын ваар савны адил төстэй байдал зөвхөн хэлбэр хэмжээгээр хязгаарлагдахгүй мөн наамал хээнүүд, спираль хээг дурдах хэрэгтэй. Пазырыкийн ваар сав хожуу үеийн соёлуудад, түүний дотор Хүннүгийн соёлд хэрхэн нөлөөлсөн асуудал одоогоор бүрэн боловсроогүй байна. В.Д.Кубаревын үзэж байгаагаар Орос Алтайн пазырыкийн зарим домбоны хэлбэрийг Хүннүгийн дурсгалуудаас харж болох бөгөөд ялангуяа Юстыд голоос илэрсэн Хүннүгийн шавар ваар шатаах зуухнаас олдсон олон ваарнууд адил төстэй байгаа ажээ [Кубарев, 1991: 61].

Пазырыкийн ваар савыг туузан аргаар гараар барьдаг байжээ. Иймээс ч хэлбэр ба хэмжээний хувьд маш их хэлбэлзэлтэй, хоорондоо адил ваар бараг байдаггүй онцлогтой юм. Энэ талаараа Хүннүгийн үеэс эрс ялгарч байгаа бол хөрш зэргэлдээх чандмань-сагилын соёлын ваартай ижилсэж байгаа.

Эдгээр ваарны дотор тооны хувьд илт давамгайл байдалтай нь домбо бөгөөд гурван хэлбэрээр тавьсан баялаг хээ чимэглэлтэй, сайн шатаалт, өнгөлж боловсруулсан гадарга зэргээрээ бусад хоёр төрлөө давамгайлна. Домбоноос хамгийн их ялгаатай нөгөө төрөл бол хотго юм. Хэрэв домбо ихэвчлэн хоолны ширээн дээр хэрэглэдэг ваар байсан бол хотго ихэвчлэн гал зуухны зориулалтаар ашиглагддаг байсан болов уу. Гуравдугаар төрөл болох бутан бол хэлбэрийн хувьд дээрх хоёр төрлийн дундын байр суурьтай бөгөөд хосолмол

зориулалтаар ашиглагддаг байжээ.

Пазырыкийн ваар савыг оршуулгын ёслолд зориулж тусгайлан хийдэг гэсэн таамаглал их дэлгэрсэн байдаг. Ялангуяа домбо бол суурин газруудаас бараг гардаггүй, мөн булшны дараас чулуун дээрээс ч гардаггүй тул “сакраль” шинжтэй гэж үздэг. Гэвч Харганат-IV дурсгалын 2-р булшнаас гарсан нэгэн домбо дотроос амьтны гаралтай өөх тос, сүүн бүтээгдэхүүний ул мөр гарсан нь удаан хугацаанд халааж байсан шинжтэй байжээ.

Монголын пазырыкийн ваар савыг бид хэлбэрийн хувьд 3 төрөл, түүний дотор 5 дэд төрөлд хуваан ангилав. Энэ бол нэлээд хураангуй ангилал бөгөөд Оросын судлаачдын хийдэг дэлгэрэнгүй ангиллаас эрс ялгарна. Гэхдээ хэрэв ангиллын цаана бодитой утга санаа агуулагдахгүй бол ийм хэт бутархай ангилал хийх онцын шаардлага байхгүй хэмээн үзэж байгаа тул аль болох товчоор, ваарны нэг төрөл дотор олон хувилбар байж болохыг хүлээн зөвшөөрч гол онцлогуудыг чухалчлан дээрх ангиллыг хийсэн болно. Төрөл зүйлийн хувьд Монголын хэрэглэгдэхүүн хөрш бүс нутгуудаас илүү ядмаг байна. Орос Алтайн булшнаас гардаг корчаг, банка, чайник зэрэг төрлүүд Монголоос илрээгүй байгааг дурдая.

Харин хээ чимэглэлийг 3 хэлбэрийн 9 төрөлд хуваан ангилав. Хээ чимэглэлийн хувьд Монголын пазырыкийн ваар савнууд бусад газрын олдворуудаас онцын ялгаагүй юм. Ерөнхийдөө ухмал ба наамал хээнүүд давамгайлдаг бөгөөд зурмал хээ харьцангуй цөөн байдаг нь тоон үзүүлэлтээр нийцэж байна. Орос Алтайд илэрсэн шар-улбар өнгийн будмал хээ харин Монголоос илэрсэнгүй.

Хэмжээний хувьд ваар савнууд төрөл хооронд төдийгүй төрөл дотроо ч ихээхэн ялгаатай байдаг. Оршуулгад дагалдуулсан ваарны хэмжээ нь хүний нас хүйстэй холбоотой байсан болов уу хэмээн таамаглах үндэслэл болдог.

Монголын ба нийт пазырыкийн соёлын ваар савыг ажиглахад олон төрлийн гоёмсог бөгөөд өвөрмөц хэлбэрүүд, хээ чимэглэлийн хөгжингүй урлаг, оршуулгын ба ахуйн ваарны ялгарал зэрэг олон шинжээрээ сайн хөгжиж боловсорсон ваар савны урлагтай байсныг харуулж байна. Эдгээр ваар савыг орон нутагтаа өөрсдийн урчууд хийж түгээж байсан бололтой. Гэхдээ хөрш зэргэлдээх соёлууд болон алс хол газрын хүртэл нөлөө пазырыкийн ваар саванд ажиглагдаж байна. Энэ нь уг соёл бүрэлдэн тогтоход гарал үүслийн хувьд ялгаатай бүлгүүд оролцсонтой холбоотой байж мэднэ. Мөн нэг булшинд 1-4 хүртэл шавар ваарыг дагалдуулдаг байсан байна. Харин 1 тохиолдолд буюу ХАР-IV дурсгалын 1-р булшинд оршуулсан

7 хүнд 10 ваар сав хийсэн байжээ.

Цаашид Монголын пазырыкийн ваар савны технологийн асуудлыг болон археологийн судалгааны хамгийн чухал асуудал байсаар ирсэн он цагийн асуудлыг дэлгэрүүлэн авч үзэх шаардлагатай байна. Мөн оршуулгын зан үйлийн хүрэн дэх ваар савны асуудал ч судлагдах учиртай.

### Талархал

Монгол-Францын хамтарсан “Евразиаг” төсөлд хамтран ажиллах санал тавьж олон жил удирдан хамтран ажилласан доктор, профессор Ц.Төрбат, Х.П.Жискард, академич, доктор, профессор Д.Цэвээндорж, доктор Т.Батбаяр, Н.Баярхүү, Т.Идэрхангай, Г.Энхбаяр, Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн судалгааны багт ажиллах хүсэлтийг тавьж хамтран ажилласан доктор Н.Батболд, сэргээн засварлагч Н.Нандинцэцэг, Солонгосын талын судлаачид Буён Юнг Хван, Жон Сон Мук, Ким Кон Ву, Нам Сан Вон болон нэгэн сэтгэлээр хамтран ажилласан бусад олон судлаач, туслах ажилчид, оюутнууд найз нартаа болон тус өгүүллийг бичихэд бүхий л талаар тусалж дэмжсэн доктор, профессор Ц.Төрбат, Н.Баярхүү нартаа талархал илэрхийлж та нартаа хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

### Ном зүй

**Болдхуяг, 2003** - Д.Болдхуяг. Вааран савны нэр томъёоны асуудалд // *Studia Archaeologica*. Том XXI, Fasc. 15. УБ., 2003. Тал 143-152.

**Вадецкая, 1986** - Э.Б.Вадецкая. Археологические памятники в степях Среднего Енисея. Л., 1986. Стр. 180.

**Кирюшин, Степанова, 2000** - Ю.С.Кирюшин, Н.Ф.Степанова. Расписная керамика скифского времени могильника Тыткескень-VI со Средней Катуни. Актуальные вопросы истории Сибири: Вторые науч. чтения памяти профессора А.П. Бородавкина. Барнаул, 2000. Стр. 35-40.

**Кирюшин, Степанова, 2004** - Ю.С.Кирюшин, Н.Ф.Степанова. Скифская эпоха Горного Алтая. Ч. III: Погребальные комплексы скифского времени Средней Катуни. Барнаул. 2004. Стр. 292.

**Кирюшин, Степанова, Тишкин, 2003** - Кирюшин Ю.Ф., Степанова Н.Ф., Тишкин А.А. Скифская эпоха Горного Алтая. Ч. II: Погребально-поминальные комплексы пазырыкской культуры. Барнаул. 2003. Стр. 234.

**Кубарев, 1987** - В.Д.Кубарев. Курганы Уландрыка. Новосибирск. 1987. Стр. 202.

**Кубарев, 1990** - В.Д.Кубарев. Расписные сосуды из курганов Алтая. Проблемы изучения

древней и средневековой истории Горного Алтая. Горно Алтайск. 1990. Стр. 31-35.

**Кубарев, 1991** - В.Д.Кубарев. Курганы Юстыда. Новосибирск. 1991. Стр. 191.

**Кубарев, 1992** - В.Д.Кубарев. Курганы Сайлюгема. Новосибирск. 1992. Стр. 219.

**Кубарев, 2001** - В.Д.Кубарев. Бике-I, III: Погребальные памятники скифской эпохи Средней Катуни. Древности Алтая. 2001. №7. Стр. 120-145.

**Кубарев, Шульга, 2007** - В.Д.Кубарев, П.И.Шульга. Пазырыкская культура (курганы Чуй и Урсула). Барнаул, 2007. Стр. 280.

**Маннай-Оол, 1970** - М.Х.Маннай-Оол. Тува в скифское время (уюкская культура). М., 1970. Стр. 116.

**Марсадалов, 2004** - Л.С.Марсадалов. Глиняные сосуды Горного Алтая VIII-III веков до н.э. Археология и Этнография Алтая. Институт Алтаистики Им. С.С.Сурзакова. 2004. №2. Стр. 37-51.

**Мерц, 2015** - В.К.Мерц. Система адаптации древних скотоводов в горностепной зоне Северной Евразии и методы поиска их поселений. Археология Западной Сибири и Алтая: опыт междисциплинарных исследований. Сборник статей, посвященный 70-летию профессора Ю.Ф.Кирюшина. Ред. А.А.Тишкин. Барнаул, 2015. Стр. 69-74.

**Миронов, 2000** - В.С.Миронов. Культура населения средней Катуни в скифское время. Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Институт археологии и этнографии СО РАН. 2000. Стр. 253.

**Молодин, Ламина, 2000** - В.И.Молодин, В.В.Лamina. Технологический анализ керамических сосудов. Феномен алтайских мумий. Новосибирск, 2000. Стр. 140-143.

**Му, 2023** - Ц.Му. Керамическая посуда из погребальных памятников пазырыкской культуры Скифо-Сакского времени: комплексные исследования и реконструкция. Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Том I. Текст диссертации. Алтайский Государственный Университет, 2023. Стр. 734.

**Мэнэс, 1985** - Г.Мэнэс. Керамика чандманьской культуры (VII-III вв. до н.э.). *Studia Ethnographica*, Tomus 9. Fasc. 6. Тал 34-47.

**Смирнов, 1964** - К.Ф.Смирнов. Савроматы. Ранняя история и культура сарматов. М., 1964. Стр. 377.

**Сорокин, 1974** - С.С.Сорокин. Цепочка курганов времени ранних кочевников на правом берегу реки Кок-су (Южный Алтай).

Археологический Сборник Государственного Эрмитажа. 1974. №16. Стр. 62-91.

**Степанова, 1998** – Н.Ф.Степанова. К вопросу о терминологии и типологии керамики раннего железного века Горного Алтая. Древние поселения Алтая. Сборник научных трудов. Ред. Ю.Ф.Кирюшин, А.Л.Кунгуров. Барнаул, 1998. Стр. 137-145.

**Степанова, Мерц, 2016** - Н.Ф.Степанова, В.К.Мерц. Керамика поселения Шар-Говь-4 (Северо-Западная Монголия). ТПАИ. №3 (15). 2016.Стр. 83-89.

**Суразаков, 1989** – А.С.Суразаков. Горный Алтай и его северные предгорья в эпоху раннего железа. Проблемы хронологии и культурного разграничения. Горно-Алтайск, 1989. Стр. 216.

**Цэвээндорж, Молодин, Парцингер, 2016** - Д.Цэвээндорж, В.И.Молодин, Х.Парцингер. Монгол Алтайн пазырыкийн соёлын цэвдэгт булш, УБ., 2016. Тал. 248.

**Эрэгзэн, 2016** – Г.Эрэгзэн. Хүннүгийн шавар сав. Ред. Ц.Төрбат. Монголын эртний шавар сав. Монголын археологийн өв. Боть VI. УБ., 2016. Тал 92.

**Laboratoire Garnier, 2010** - N.Laboratoire Garnier. Rapport d'analyses organiques. Sites de Kharaganat et Syrgal. Altai Mongol, Analyses effectuées a la demande de: Institut des deserts et des steppes, 6 rue Masseran, 75007 Paris. Paris: Laboratoire N.Garnier, 2010. pp. 23.

**Novgorodova et al, 1982** - E.A.Novgorodova, V.V.Volkov, S.N.Korenevskij, N.N.Mamonova. Ulangom. Ein skythenzeitliches Gräberfeld in der Mongolei. Wiesbaden: Otto Harrassowitz, 1982. pp. 173.

**Батболд, Батсүх ба бусад, 2016** - Н.Батболд, Д.Батсүх, Г.Энхбаяр, Н.Нандинцэцэг, Бён Юн Хван. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан, Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төсөл. УБ., 2016. Тал 62.

**Батболд, Батсүх ба бусад, 2017** - Н.Батболд, Д.Батсүх, Н.Баярхүү, Н.Нандинцэцэг, Буён Юнг Хван, Ким Кон Ву. Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2017 оны ажлын тайлан. УБ., 2017. Тал 45.

**Батболд, Батсүх ба бусад, 2018** - Н.Батболд, Д.Батсүх, Н.Баярхүү, Жон Сон Мук, Ким Кон Ву. Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны ажлын тайлан. УБ., 2018. Тал 70.

**Батсүх, Баярхүү, 2013** - Д.Батсүх, Н.Баярхүү. Монгол-Францын хамтарсан “Eurasiat” төслийн археологийн хээрийн шинжилгээний ангийн 2013

оны ажлын тайлан. Улаанбаатар, 2014. Тал 48.

**Баярсайхан, Эгиймаа, Бүрэнтөгс, 2012** - Ж.Баярсайхан, Ц.Эгиймаа, Г.Бүрэнтөгс. Монгол-Америкийн хамтарсан “Билүүт” археологийн судалгааны төслийн 2012 оны хээрийн судалгааны тайлан. Монголын Үндэсний музей. УБ., 2012. Тал 60.

**Төрбат, Батсүх, 2005** - Ц.Төрбат, Д.Батсүх. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт ажилласан археологийн экспедицийн тайлан. Цэнгэл-Улаанбаатар, 2005. Тал 21.

**Төрбат, Батсүх ба бусад, 2006** - Ц.Төрбат, Д.Батсүх, Т.Батбаяр, Н.Баярхүү. Монгол-Европын холбооны хамтарсан “Eurasiat” төслийн археологийн хээрийн шинжилгээний ангийн 2006 оны ажлын тайлан. - Цэнгэл-Улаанбаатар, 2006. Тал 43.

**Төрбат, Батсүх, Батбаяр, 2007** - Ц.Төрбат, Д.Батсүх, Т.Батбаяр. Монгол-Европын холбооны хамтарсан “Eurasiat” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2007 оны ажлын тайлан. УБ., 2008. Тал 75.

**Төрбат, Батсүх, Баярхүү, 2009** - Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү. Монгол-Францийн хамтарсан “Eurasiat” төслийн археологийн хээрийн шинжилгээний ангийн 2009 оны ажлын тайлан. Улаанбаатар, 2010. Тал 71 (a).

**Төрбат, Батсүх, Баярхүү, 2010** - Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү. Монгол-Францийн хамтарсан “Eurasiat” төслийн археологийн хээрийн шинжилгээний ангийн 2010 оны ажлын тайлан. - Улаанбаатар, 2010. Тал 107 (b).

**Төрбат, Батсүх, Баярхүү, 2011** - Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү. Монгол-Европын холбооны хамтарсан “Eurasiat” төслийн археологийн хээрийн шинжилгээний ангийн 2011 оны ажлын тайлан. Улаанбаатар, 2011. Тал 57.

**Төрбат, Батсүх, Баярхүү, 2012** - Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү. Монгол-Францын хамтарсан “Eurasiat” төслийн археологийн хээрийн шинжилгээний ангийн 2012 оны ажлын тайлан. Улаанбаатар, 2012, Тал 56.

**William W. Fitzhugh and Richard Kortum, 2012** - William W. Fitzhugh and Richard Kortum, Editors, Maegan Tracy, Producer. Rock Art and Archaeology: Investigating ritual Landscape in the Mongolian Altai Field report 2011. Ulaanbaatar, 2012. pp. 178.

**William Fitzhugh, Richard Kortum and Jamsranjav Bayarsaikhan, 2012** - William Fitzhugh, Richard Kortum, and Jamsranjav Bayarsaikhan, Editors, Ming Archbold and Laura Sharp, Producers. Rock Art and Archaeology: Investigating ritual Landscape in the Mongolian Altai Field report 2012. Ulaanbaatar, 2013. pp. 218.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non

Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.

Хүснэгт 8. Монголын пазырыкийн ваар савны шинж чанар ба тоон үзүүлэлтүүд

№	Оршуулгын нөлөөлбөр	Булшны дугаар	Олдворын дугаар	Төлөв			Хээ чимэглэл					Төрөл			Хэмжээ (см)				
				Сэргэсэн	Хэсэгчлэн сэргэсэн	Сэргээх боломжгүй	Ухмал	Зурмал	Наамал	Чихтэй	Хээгүй	Домбо	Бутан	Хотго	Өндөр	Амрын голч	Бөөрний голч		
1	БТГ-I	1	3			1													
2		2	4			1		1											
3		7	2		1												10,5		
4		8	8			1		1											
5			45			1													
6			48			1													
7			49			1		1											
8	БТГ-VI	3	2		1					1				20,5	9,5	14			
9		8	3	1				1		1				27,2	8,4	39,2			
10		10	3		1														
11			4	1						1				21,2	9,6	14,8			
12		11	3	1								1		17,3	9,5	12,5			
13			10		1								1		11,5				
14		12	2	1			1				1			24,2	11	16,2			
15	13	4		1						1				6,8					
16	ЦХ-I	2	12			1		1											
17		3	4	1					1				1	17,6	8,2	12			
18	5				1														
19	ЦХ-III	1	4			1													
20	ЦХ-V	2	2		1					1					9	20,5			
21			7			1													
22		8	1							1			23	7,8	15				
23		3	2		1								1		10				
24	4				1														

25	ХАР-IV	1	5		1												9,5				
26			6	1									1					18,9	8,6	15	
27			7	1								1						11,9	5,2	7,7	
28			8	1								1						15,4	6,9	9	
29			9	1									1					21,5	6,6	18,5	
30			10			1									1				9	18	
31			11				1														
32			12				1														
33			13				1														
34			14				1														
35			2	4	1					1			1						17,8	6,4	11
36			СЫР-I	1	31		1						1							9,5	
37					33		1													11,5	
38			СЫР-II	1	4	1				1			1						33,4	7,7	22
39	8	4			1			1						1			13,4	6,6	10,4		
40		10		1			1							1		17,8	7	10,8			
41	СЫР-III	1	15a		1																
42			156		1													5,8			
43	ХАТ-I	1	18		1				1				1				18,8	10,5	13,2		
44			2	4		1								1				30	8,2	14,5	
45	ХАТ-II	1		1					1								23,2	11,2	18		
46	ХАТ-III	6	3		1				1				1					8,5			
47			5		1				1				1					9,5	16		
48			8			1															
49			ЦС	1	17		1														
50	18				1																
51	3	4				1															
52	5	3				1															
53	6	1				1															
54	10	3				1															
55		35				1								1				12	15		
56	БЛТ-II	2	1	1				1				1					18	5,9	15		
57		(2-1)	1	1			1		1				1				23	8,4	14,5		
58	ОГГ-VI	2	1			1															
59			2			1															
60	ОГГ-X	1	5	1							1						36,7	10,2	23,8		
61	ШХ	1	1	1	1			1				1					28,7	9,8	16,5		
62			1			1															
63			2	2			1														
64			10				1														
65			3	5	1								1					35,8	11,7	20	
66			6	1			1														
67			7	2	1			1					1					23	11	12	
68			9	2	1										1			23,5	10,5	16	
			<b>НИЙТ</b>	<b>40</b>		<b>22</b>	<b>19</b>	<b>27</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>4</b>		<b>15</b>	<b>3</b>	<b>10</b>	<b>6</b>				